

Монгол хэлний интерактив дасгал 2

Зааварчилгаа

1. Даалгавраа гүйцэтгэж дуусаад **Finish!!** дараарай.
2. Зөв хариулт ногоон, буруу хариулт улаанаар тэмдэглэгдэнэ

3.



Check my answers



Email my answers to my teacher

Дарж авсан
оноогоо хараарай

4. Авсан оноо нь шууд гарна
оноотойгоо танилцаарай.



Амжилт хүсье



LIVEWORKSHEETS

Эхээ сайтар уншиж ойлгоод дараах даалгаврыг гүйцэтгээрэй

ШИДЭТ МАЛГАЙ

Биднийг дөрөвдүгээр ангид орох намар Дундговь аймгаас нэг хүүхэд шилжиж ирлээ. Тэр бид хоёр дотно найзууд боллоо. Учир нь хоеуланд маань нэгэн ижил зүйл байсан юм. Би ангийнхандаа үлгэр ярьж байгаад зарим хэсгийг нь мартчихвал Дондог шууд л зохиогоод ярьчихна. Естой л ангайтал ярьж түс хийтэл инээд алдуулна шүү дээ.

Түүнийг ирээд удаагүй байтал Мөнхөөгийн төрсөн өдөр болж биднийг урилаа. Хорин хэдүүлээ ширээ тойрон суугаад дайлуулж гарлаа даа. Тэгтэл нэг нь:

-Дондог оо, чи өндөг идэж үзээгүй юм уу? Говьд нээрээ өндөг байдаггүй байх л даа гэлээ. Тэгтэл Дондогийн нүд нь сэргэж, биднийг тойруулан харснаа нэг өндөг аваад:

-Өө би үүнийг үрлэн чихэр гэж бодсон юм. Энэ чинь тэгээд өндөг юм уу? гэлээ. Бүгд түүнийг гайхан харвал ер анзаарсан шинжгүй:

-Манай говийн шувууны өндөг хүний толгойн чинээ том байдаг юм. Ангиараа идсэн ч нэг өндгийг барахгүй гэж хэнэг ч үгүй хэллээ.

-Арай ч үгүй байлгүй дээ.

-Та нар говиос олдсон үлэг гүрвэлийн өндөг хараагүй юм уу?

-Харах нь харсан л даа. Тэр чинь олон зуун сая жилийн өмнө мөхсөн амьтан шүү дээ.

-Тийм нь ч тийм. Гэхдээ манай говьд нисдэг үлэг гүрвэлүүдийн удам аварга том шувуунууд одоо ч байдаг юм. Зарим өдөр аварга том шувуунууд нар халхалж нисээд л сүртэй шүү дээ. Өндөг нь энэ данхнаас том.

Манай ангийнхан түүний яриаг сонсоод гайхаж итгэж ядаж байлаа.

-Ха ха монхойчхоод догь залж байна шүү гэх дуунаар эргэн харвал Мөнхөөгийн ах нь ирчихэж. Энэ өдрөөс хойш Догь монхор хочтой болж, сонин хачин түүх ярьдгаараа алдаршив.

-Нэгэн удаа Дондог говьд луу гэж амьтан байдаг тухай ярилаа. Тэр луу нь найман бөхтэй, дөрвөн том далавчтай. Амнаас нь гал дүрэлзээд л уурлахаараа ургаа модыг хугарч унатал сүүлээрээ шавхуурддаг. Сайхан ааштай үедээ говийн хүүхдүүдийг нуруундаа суулгачхаад л номин хөх тэнгэрээр зугаацуулж явдаг гэнэ. Ингээд л лууны тухай яриа ид өрнөж байтал багш орж ирлээ. Тэгтэл нэг нь:

-Багш аа говьд аварга том, нисдэг луу байдаг юм уу? гэж асуулаа. Багш инээгээд:

-Дондог тэгж байна уу? гэлээ. Дондог тэгтэл:

-Багш аа! манай Лувсан өвөө хүрэн атаа Луу гэж нэрлэсэн байхгүй юу. Өвөөгийн хүрэн лууны тухай найзууддаа ярьсан юм гэдэг байгаа. Гэхдээ л Дондогийн энэ яриа үнэхээр сонирхолтой байсан юм.

Бас нэгэн удаа зургийн хичээл дээр малгай зурлаа. Багш бидний дундуур явж байгаад Дондогийн зургийг үзээд:

-Энэ чинь харин сонин малгай байна даа. Ингэж л урнаар сэтгэж зурах хэрэгтэй гэж магтлаа. Нээрээ л далбийсан хүрээтэй, шовойсон өндөр оройтой хачин янзын малгай байв. Би завсарлагаанаар:

-Яагаад ийм сонин малгай зурснаа ярьж өгөөч гэхэд:

-Надад яг ийм малгай байсан юм. Манай найзууд миний малгайг "Марзан шовгор" гэдэг байлаа. Хүүхэд бүхэн өмсөж үзэх гээд л гуйна. Марзан шовгор малгайг өмссөн хүүхдийн толгойд ид шид орж ирдэг байсан юм. Харамсалтай нь би энэ малгайгаа гээчихсэн л дээ. Нэг зун ахтайгаа мөнгөн цагаан онгоцоо хөлөглөн толгойгоо цухуйлгачхаад од шүүрэн алдан нисэж явлаа шүү дээ. Гэтэл хавирган саранд марзан шовгор малгай минь өлгөгдөж унаад би толгой нүцгэн хоцордог байгаа гэж Дондогийг ярихад:

-Ха ха, хи хи. Ёстой л жинхэнээсээ залж орхилоо доо гэж анги дүүрэн инээлдлээ. Ийнхүү Догь монхрыг байхад бид дандаа хөгжилдөж инээлдэж байдаг байлаа.

-Гэтэл нэг өдөр тэр хичээлдээ ирсэнгүй. Бүгд л түүнийг үгүйлж, "Арай говь нутаг руугаа буцчихсан юм биш байгаа" гэж харамсаж байлаа. Хичээл тарахын өмнөхөн ээж нь ирж багштай уулзаад:

-Дондог маань ханиад хүрчихжээ гэлээ. Бид хичээл тараад гэр гэрийн зүг явсангүй. Харин цуглаж дэрвэгэр хүрээтэй, шовгор малгайг хатуу цаасаар урлаж дээр нь "Чи бол шидэт үлгэрийн зохиолч. Одоо бид ч бас ид шидтэй болсон. Тэгээд чамд зориулж шидэт малгай хийлээ. Энэ малгайг өмссөн хүүхдийн ханиад тэр дорхноо эдгэдэг юм. Чи ид шидэд итгэдэг болохоор амархан эдгэнэ ээ" гэж бичлээ. Ингээд манай ангийн охид хөвгүүд шидэт малгайгаа барьсаар Дондог найзындаа очлоо. Биднийг хараад баярлаж хөөрсөн Догь монхор маань шидэт малгайг өмсөнгүүтээ эв эрүүл болсон юм даа.

О.Сундуй

УНШИХ ЧАДВАРЫГ СОРЬСОН ДААЛГАВАР: Зөв хариултыг сонгоорой

1. "Ёстой л ангайтал ярьж **түсхийтэл** инээд алдуулна шүү дээ." тодруулсан үгийн утгад тохирох хэсгийг сонгоно уу.

A. гэнэт

B. үргэлж

C. хааяа

D. дандаа

2. "Хавирган саранд марзан шовгор малгай минь өлгөгдөж унасан" гэсэн нь уран зохиолын ямар дүрслэл байна вэ?

A. Амьдчилал

B. багасгал

C. зүйрлэл

D. ихэсгэл

3. Дондогийн хэтрүүлэн ярьсан зүйлсийн зөв дарааллыг сонгоно уу.

A. лууны тухай, малгайны тухай, онгоцны тухай, өндөгний тухай

B. лууны тухай, онгоцны тухай, малгайны тухай, өндөгний тухай

C. өндөгний тухай, малгайны тухай, онгоцны тухай, лууны тухай

D. өндөгний тухай, лууны тухай, малгайны тухай, онгоцны тухай

4. "... говиос олдсон үлэг гүрвэлийн өндөг хараагүй юм уу?" өгүүлбэрийг гүйцээж бичихэд цэгийн оронд төлөөлөх утгатай үгийг нөхөж бичээрэй.

5. Лувсан өвөө хүрэн атандаа ямар нэр өгсөн бэ?

A. Гал

B. Луу

C. Найман бөхт

D. Тэнгэр

6. Зургийн хичээл дээр багш яагаад Дондогийн зургийг магтсан бэ?

A. гоё сайхан зурсан учраас

B. далбийсан хүрээтэй малгай байсан учраас

C. уран сэтгэж зурсан учраас

D. Дондогт ийм малгай байсан учраас

7. "Манай ангийнхан түүний яриаг сонсоод гайхаж итгэж ядаж байлаа." гэсэн өгүүлбэрээр сэтгэлийн ямар өнгө аястай байна вэ?

A. баталсан өнгө аястай өгүүлбэр

B. магтан сайшаасан өнгө аястай өгүүлбэр

C. зөвлөсөн өнгө аястай өгүүлбэр

D. эргэлзсэн өнгө аястай өгүүлбэр

8. Зөв холбоорой.

"Бид хичээл тараад гэр гэрийн зүг
явсангүй."

Уран сэтгэмж

"Манай говийн шувууны өндөг хүний
толгойн чинээ том байдаг юм."

Бодит байдал

9. Дондог яагаад сургуульдаа алдаршсаныг тайлбарлан бичнэ үү.

.....

10. Дараах өгүүлбэрийг орон байр, цаг хугацаа заасан үгээр дэлгэрүүлэн бичээрэй.

..... хичээл тар..... ээж нь ирж багштай уулзав.

Баяр хүргэе

